




МОНГОЛ ДААТГАЛ

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**
2019



АЛСЫН ХАРАА

Даатгалын иж бүрэн үйлчилгээг айл өрх, албан байгууллага бүрт хүргэсэн дэлхийн жишиг компани байна

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид харилцагч төвтэй, мэргэшсэн, ёс зүйтэй даатгалын үйлчилгээг шилдэг шийдлээр хүртээмжтэй хүргэж итгэлтэй ирээдүйг бүтээлцэнэ



ЛОГОНЫ БЭЛГЭДЭЛ



Айл өрх
Аж ахуйн нэгж



Уул мэт түшигтэй



Хоёр давхар
хамгаалагдсан



Бат бэх суурь
итгэлтэй

УУЛ МЭТ ТҮШИГТЭЙ

Монголын даатгалын түүхэн компанийн уламжлал, соёл, санхүүгийн чадамж, хүчин чадалдаа суурилан харилцагчдийнхаа аливаа эрсдэлд өөриймсөг хандан, удирдан чиглүүлж, эрсдэлийг хамтдаа даван туулж тайван амгалан байхын бэлгэдэл.

ИТГЭЛТЭЙ ХАМТРАГЧ

Хэрэглэгчийнхээ хүсэл хэрэгцээг ямагт сонсон, ойлгож, тэдэнд зориулсан үйлчилгээг санал болгон мэргэжлийн түвшинд үйлчлэн, сэтгэл ханамжийг байнга нэмэгдүүлэн, халамжилж, эргэх холбоотой байж урт хугацааны итгэлцлийг бий болгон ажиллахын бэлгэдэл.

ТӨГС ГҮЙЦЭТГЭЛ

Олон улсын стандартад нийцсэн үйл ажиллагаа, мэргэжлийн чадварлаг боловсон хүчинд тулгуурлан хэрэглэгч, харилцагчдынхаа үнэ цэнэд нийцүүлсэн шилдэг шийдлийг санал болгосноор оновчтой үйл ажиллагааг бий болгохын бэлгэдэл.



ӨНГӨНИЙ БЭЛГЭДЭЛ

Монгол түмний бахархал, хүндэтгэл шингэсэн гэр сууцыг бид мөнх хөх тэнгэр, эдийн эх хадагны цэнхэр өнгөөр илэрхийлсэн нь харилцагчдаа ямагт дээдэлж, тэдний тайван амгалан амьдралын төлөө зүтгэж, итгэлцэл, үнэнч байдлыг аливаа харилцаандаа нягт тусгаж ажиллахыг харуулж байна.

ДҮРСНИЙ БЭЛГЭДЭЛ

Даатгалын салбарын өв уламжлалыг хадгалагч компанийн хувьд Монгол түмний гэр сууц бүхий бэлгэдлийг энэхүү сүлд тэмдгэндээ хадгалж, уг гэр сууцыг бид айл өрх, аж ахуй нэгжээр төлөөлүүлсэн бөгөөд манай үйл ажиллагаа нь хоёр давхар хамгаална гэсэн бат илэрхийллийг энэ дүрслэлээр гаргаж байна.





ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Эх орныхоо тайван амгалан, иргэдийнхээ тав тухтай амьдрал, Монгол улсынхаа хөгжлийн төлөө өдөр бүр зогсолтгүй ажиллаж байгаа эрхэм бизнес эрхлэгч та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе!

Монголын даатгалын салбарын үүсэл хөгжлийг эхлүүлсэн анхдагч компани "Монгол Даатгал"-ийн хувьд өөрийн өргөн мэдээллийн бааз суурь, тогтвортой соёл, мэргэшсэн чадварлаг баг хамт олонд тулгуурлан Монгол улсын 21 аймаг дахь өөрийн салбар, даатгалын борлуулалтын хамгийн өргөн сүлжээ бүхий 700 гаруй төлөөлөгчөөрөө дамжуулан харилцагч төвтэй даатгалын үйлчилгээг санал болгон, цахимаар даатгалын үйлчилгээг хүргэн, тэдний хүсэл, хэрэгцээ, сэтгэл ханамжийг 7/24 цагаар зогсолтгүй сонсож, судлан, байнгын сайжруулалтыг хийж, 2019 оны байдлаар бидэнд итгэл хүлээлгэсэн даатгуулагчдын тоо 255 мянгад хүрч, жилээс жилд нэмэгдэн, санхүүгийн голлох үзүүлэлтээр тэргүүлж байна. Бид хөгжлөөрөө ямагт анхдагч, тэргүүлэгч байгааг хэлэхэд таатай байна. Түүнчлэн бид дэлхийд нэр хүндтэй, өндөр зэрэглэлтэй, тэргүүлэгч давхар даатгалын компаниудад эрсдэлээ шилжүүлснээр харилцагчиддаа давхар даатгагдсан хамгийн өндөр багцыг санал болгох боломжийг бүрдүүллээ.

Харилцагчидтайгаа хамтдаа хөгжүүлж буй бидний бизнес өдрөөс өдөрт өргөжин тэлж байгаа нь иргэд, байгууллагуудын даатгалын мөн чанар, ач холбогдлыг ойлгох ухамсар нэмэгдсэнтэй холбоотой. Гэсэн хэдий ч хүмүүний итгэлтэй ирээдүй, амар тайван амьдралын төлөө бидний итгэл үнэмшил цуцашгүй байж, даатгалын үйлчилгээг хялбар, ойлгомжтой, хүртээмжтэй хүргэхэд тэмүүлсээр байх болно.

Монгол орныг хамарсан ДААТГАЛЫН ХАМГИЙН ӨРГӨН СҮЛЖЭЭ



УДИРДЛАГЫН БАГИЙН ТАНИЛЦУУЛГА



Гүйцэтгэх захирал
Ч.ЭНХ-АМГАЛАН



Байгууллагын даатгалын
бизнесийн газрын захирал

Т.БААСАНЖАВ



Нөхөн төлбөрийн газрын
захирал

Р.ЭНХБАЯР



Эрүүл мэндийн даатгалын
газрын захирал

Г.ГАНЖАРГАЛ



Санхүүгийн удирдлагын
газрын захирал

Н.БАТБАЯР



Үйл ажиллагаа хариуцсан
газрын захирал

О.ЭРДЭНЭБУЛГАН

КОМПАНИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

"Хорго Хайрхан" ХК-д "Монгол даатгал" ХХК-г нэгтгэхийг Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 372 дугаартай тогтоолоор зөвшөөрч "Монгол даатгал" ХК үүсэн бий болсон.

Компани нэгдсэнээр "Монгол даатгал" ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэг бүрийн 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 64.132.341 хувьцаа болж өөрчлөгдсөн.

Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч "Миллениум Секюритис Менежмент Лимитед" компани нь 63.997.215 ширхэг хувьцааг эзэмшиж байгаа бөгөөд энэ нь нийт хувьцааны 99.79 хувь юм.

Үлдсэн 135,126 ширхэг буюу 0.21 хувийн хувьцааг 242 хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.

ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Компаниуд нэгдэж "Монгол даатгал" ХК үүсэн байгуулагдсанаас хойш Төлөөлөн удирдах зөвлөл нийт 5 удаа хуралдаж 11 шийдвэрийг гаргасан байна.

Үүнд:

- 2019.12.25-ны өдрийн хурлаар, засаглалыг сайжруулах ажлын хүрээнд хувьцаат компанийн эрхэм зүйл болох Компанийн засаглалын кодексыг нэвтрүүлэхээр дараах журмуудыг батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Үүнд:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам
- Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам
- Компанийн үйл ажиллагааны ил тод байдлын журам
- Дотоод хяналтын журам
- Ногдол ашгийн бодлого

- 2019.12.26-ны өдрийн хурлаар, Компанийн салбарын гэрчилгээ, тэмдгийг шинэчлэх, Компанийн салбарын журмыг баталсан.

ТУЗ-ИЙН ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгохтой холбоотой асуудлаар дүгнэлт гаргах ажлуудыг хийж ажиллаа. Цалин урамшууллын хороо нь нийт ажилтнуудын үндсэн цалин, ажлын гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтэд суурилсан урамшууллын системийн бодлогыг баталлаа. Аудитын хороо нь компанийн санхүүгийн тайланг аудитаар хянуулж баталгаажуулсан.

ТҮҮХЭН ТОВЧОО

Монгол Даатгал ХК нь 1934 онд “Улсыг аюулаас хамгаалах газар” хэмээн Сангийн Яамны салбар нэгж болон тулгын чулуугаа тавьж үйл ажиллагаагаа эхлүүлсэн түүхтэй. Эдүгээ нэгэн наяны турш тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж, гадаад дотоодын түнш байгууллага, ард иргэддээ даатгалын үйлчилгээг тасралтгүй хөгжүүлэн хүргэж байгаа билээ.



2006

Монголд анх удаа 24/7 шуурхай дуудлагын албатай болов.

2010

hannover re

Олон улсын давхар даатгалын зах зээлийн томоохон давхар даатгагч болох “HANNOVER RE” компанитай хамтран ажиллаж эхэллээ.

2011

Даатгалын салбарт анх удаа өндөр хамгаалалттай олон улсын эрүүл мэндийн даатгалыг нэвтрүүлэв.

2012

Банкашурансыг Монголд хөгжүүлэхээр дотоодын арилжааны банкуудтай хамтран ажиллаж эхлэв.

2005

Дэлхийн банкны төслийн хүрээнд “Малын индексжүүлсэн даатгал” -ын борлуулагчаар ажиллаж эхлэв.

2003

Монгол Даатгал ХК хувьчлагдав.


1994

Монгол Даатгал ХК-ийн ажилтнууд оролцон боловсруулсан Даатгалын тухай Монгол улсын хууль хэлэлцэгдэн батлагдав.

1990

Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрт шилжив.

1934



Монгол Даатгал ХК-ийн суурь тавигдаж, анхны даатгалын үйл ажиллагааг эхлүүлэв.

1935

ЗХУ-ын Госстрах даатгалын газартай хамтран давхар даатгалын үйл ажиллагааг эхлүүлэв.

1936

“Албан байгууллага, аж ахуй нэгжийн даатгал” үйлчилгээг анх нэвтрүүлэв.

1946

Хувь хүн болон ажилтнуудад зориулсан амьдралын даатгалын бүтээгдэхүүн гаргав.

2019

ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛОВ.

Сүлд тэмдэг логогоо орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн шинэчилж ЭНГИЙН, ХЯЛБАР, УХААЛАГ шийдлийг тусгалаа.

Харилцагчдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн салбартаа анхлан ЦАХИМ ДААТГАЛЫН үйлчилгээг нэвтрүүллээ.

2018

“Буухиа хүү” мобайл аппликейшныг даатгалын салбарт анхлан гаргав.

ISO 9001:2015 ЧУТ-ны батламжаа хоёр дахь удаагаа баталгаажууллаа.

2017

ISO 9001:2015 ЧУТ-ны баталгаажуулалтын гэрчилгээг гардан авлаа.



2014

Global Banking and Finance Review байгууллагаас Монгол улсын шилдэг Даатгалын компани -аар тодров.

2016

Даатгалын салбарт анх удаа ISO 9001:2015 ЧУТ-г хэрэгжүүлж эхэллээ.

2017

Утсан даатгалын үйлчилгээг анхлан нэвтрүүлэв.

Allianz world wide сaге компанитай хамтын ажиллагааг эхлүүлэв.

1974

ОУ-ын болон гадаадын байгууллагын барилга байгууламж, тээврийн хэрэгслийн заавал даатгалыг хийж эхэллээ.

1964

“Нэгдэл хоршооллын мал сүрэг, САА-н таримал ургамлын заавал даатгал”-ыг анхлан хийв.

ОУ-ын брокер болон давхар даатгагч нартай хамтран ажиллаж эхэллээ.

1962

Улсыг аюулаас хамгаалах газар нь Улсын даатгах газар нэртэй болж өөрчлөгдөв.

1961


ХАА-н нэгдлийн тариалангийн даатгал нэвтрүүллээ.

1947

“Тээврийн хариуцлагын заавал даатгал” хийж эхлэв.

1953

Зорчигчийн амь насны даатгал гаргав.



1959

Хоршооллын байгууллагын эд хөрөнгийн заавал даатгал нэвтрэв.

1949 он Бөмбөгөр ногоон театр нь Монгол Даатгал компанид даатгалтай байсан бөгөөд нийт 3 удаагийн гал гарч үүссэн хохирлыг тус тус нөхөн олгосон байна.



БҮТЭЭГДЭХҮҮН & ҮЙЛЧИЛГЭЭ

Бид иргэд болон байгууллагуудад зориулсан Монгол дахь даатгалын бүх төрлийн үйлчилгээний хүрээнд 14 төрлийн, 70 гаруй үйлчилгээг иргэд, харилцагчдынхаа хүсэл хэрэгцээнд нийцүүлэн даатгалын хамгийн өргөн сүлжээгээр хүргэж байна.

ИРГЭДЭД ЗОРИУЛСАН ДААТГАЛЫН ХЭЛБЭРҮҮД



Гэнэтийн осол, эмчилгээний даатгал



Хөрөнгийн даатгал



Автотээврийн хэрэгслийн даатгал



Хүртээмжтэй даатгал

БАЙГУУЛЛАГАД ЗОРИУЛСАН ДААТГАЛЫН ХЭЛБЭРҮҮД



Гэнэтийн осол, эмчилгээний даатгал



Хөрөнгийн даатгал



Автотээврийн хэрэгслийн даатгал



Жолоочийн хариуцлагын даатгал



Хариуцлагын даатгал



Газар тариалангийн даатгал



Мал, амьтдын даатгал



Агаарын хөлгийн даатгал



Ачааны даатгал



Барилга угсралтын даатгал



Санхүүгийн даатгал



Итгэлцлийн даатгал



Агаарын хөлгийг өмчлөх эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал



НӨХӨН ТӨЛБӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Бид харилцагчийн нөхөн төлбөрийн хүсэлт ирснээс хойш нөхөн төлбөрийн тусгай баг тухайн осол, эрсдэлийг газар дээр нь өөрийн болон мэргэжлийн багийн үнэлж баталгаажуулсныг үндэслэн нэхэмжилсэн мөнгөн дүнгээсээ хамааран ажлын 3-5 хоног, өндөр дүнтэй тохиолдолд хамтын гэрээний дагуу нөхөн төлбөрийг шуурхай шийдвэрлэн олгодог.

ШУУРХАЙ АЛБАНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Манай Шуурхай алба нь ослын дуудлага хүлээн авснаас хойш орчин нөхцөл өөрчлөгдөхөөс өмнө очиж, хохирлыг баталгаажуулах зорилгоор долоо хоногийн 24 цагаар Улаанбаатар хотын замын ачааллаас хамааран дөрвөн цэгт хуваагдан ажиллаж байна. Бид Шуурхай албаны ажилтнуудынхаа ур чадвар, мэдлэгт онцгой анхаарч харилцагчийн хохирлыг бодитой үнэлэхэд байнга мэргэшүүлж ажилладаг юм.

ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Хэрэглэгч төвтэй байж, харилцагчтайгаа ойрхон тэдний дуу хоолойг сонсон, үйл ажиллагаандаа тусган сайжруулж, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нь нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээгээр үйлчлэхийг манай баг хамт олон гол зорилгоо болгон хичээн ажилладаг билээ. Бид үйлчилгээндээ харилцагч төвтэй байнгын сайжруулалтыг тасралтгүй хийдэг билээ.

Даатгалын лавлах 1800-1990 төв нь харилцагч нарт даатгалын мэдээлэл зөвлөгөө өгөх, даатгалын үйлчилгээ үзүүлэх, даатгалын тохиолдолын бүртгэл хийх үйлчилгээг үзүүлдэг бөгөөд 2019 онд нийт 119,942 дуудлага амжилттай хүлээн авч, нийт 36 гомдол, саналыг шийдвэрлэн ажилласан байна.



ДАВХАР ДААТГАЛ

Бид хүлээн авсан эрсдэлээ үнэлэн, шинжилгээ хийж, өөрийн төлбөрийн чадвар, эдийн засгийн чадавх, макро эдийн засгийн өөрчлөлт, хандлагатай уялдуулан дэлхийн томоохон, нэр хүндтэй давхар даатгагч нарт эрсдэлийн багцаа Трити болон факультатив байдлаар нэг бүрчлэн давхар даатгуулдаг.

Бид давхар даатгагчдын санхүүгийн найдвартай байдлыг нэн түрүүнд чухалчлан, санхүүгийн хүчин чадлын үнэлгээгээр A.M.Best "A-", S&P "BBB"-ээс дээш үнэлгээтэй нэр хүнд бүхий зах зээлд тэргүүлэгч давхар даатгагчаар даатгуулдаг.

Манай факультатив давхар даатгалын эрсдэлийг Их Британи, Герман, Сингапур, Хон-Конгд байрласан санхүүгийн хүчин чадлын зэрэглэл тогтоогч Standard & Poor's, A.M.Best, Fitch-ийн өндөр үнэлгээ бүхий давхар даатгалын компаниуд хүлээн авдаг.

Дэлхийд нэр хүндтэй, өндөр үнэлгээтэй, томоохон давхар даатгагч нар нь манай эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлэхээс гадна, харилцагчдад хамгийн найдвартай, өндөр түвшний даатгалын хамгаалалт болон түргэн шуурхай үйлчилгээ авах боломжоор хангаж байгаа юм.


Давхар даатгах нөхцөлүүд:

- 12,5 сая ам.доллар хүртэлх үнэлгээтэй даатгалын гэрээнүүдийг багцын давхар даатгалын гэрээний дагуу автоматаар хамгаалалтад багтана.
- Багцын давхар даатгалын хамгаалалтаас давсан өндөр үнэлгээ бүхий эсвэл онцгой төрлийн үйл ажиллагаа явуулдаг харилцагчидтай факультатив давхар даатгалын гэрээг байгуулна.
- Олон улсын эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалын үйлчилгээг дэлхийн нэр хүндтэй, даатгалын зах зээлд тэргүүлэгч давхар даатгалын компаниуд MAPFRE ASSISTANCE болон Allianz Worldwide Care-тай хамтран харилцагч нартаа хүргэж байна.

Бид хүлээн авсан эрсдэл бүртээ шинжилгээ хийж шаардлагатай тохиолдолд давхар даатгалын хамгаалалтаар бүрэн хангаж харилцагчдынхаа найдвартай түнш байх зорилгоо тогтмол биелүүлсээр байна.



ДАВХАР ДААТГАЛЫН ТҮНШҮҮД



БИДНИЙГ СОНГОХ ШАЛТГААН



САЛБАРЫН ТЭРГҮҮЛЭГЧ

86 жилийн түүхтэй Монгол Даатгал ХК нь салбарын анхны компани, ололт амжилтуудыг бүтээж ажиллагчийн хувьд өөрийн өргөн мэдээлэл, технологийн дэвшлүүдийг ашиглан харилцагчдынхаа эрсдэлд бодитой үнэлэлт өгөх туршлагатай байж санхүүгийн голлох үзүүлэлтээр ямагт тэргүүлэгч нь байсаар ирлээ.



САНХҮҮГИЙН ЧАДАМЖ

Даатгалын зах зээл дэх хамгийн том нөөц сангийн хамгаалалт болон 12.5 сая ам.доллар хүртэлх үнэлгээтэй даатгалын гэрээнүүдийг олон улсад нэр хүндтэй, зах зээлд тэргүүлэгч давхар даатгалын компаниудаар багцын давхар даатгалын гэрээний дагуу харилцагч бүрийг автоматаар хамгаалалтад авдаг.



БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙ

Даатгалын зах зээлд ёс суртахууны өндөр хэм хэмжээнд мэргэжлийн төвшинд эрсдэлийн удирдлагын зөвлөгч байж, олон улсын жишигт хүрсэн үйлчилгээг үзүүлэн, тэдний санхүүгийн асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэн ажиллаж, гэрээгээр хүлээсэн үүргээ нэр төртэйгээр биелүүлэн ажиллаж байна.



ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ТЭРГҮҮЛЭГЧ

Харилцаа, итгэлцэлд суурилдаг манай бизнест бид харилцагчийнхаа санал хүсэлтийг 7/24 цагаар хүлээн авч шуурхай шийдвэрлэн, эрсдэлийн төрөл бүрийн сургалт зөвлөгөө өгөх зэргээр харилцагчдыг эрсдэлээс хамгаалахад бүх талаар анхаарал хандуулан тэдний сэтгэл ханамжийг эрхэмлэж ажилладаг.



МЭРГЭШСЭН БАГ

Харилцагчдынхаа эрсдлийг бодитой үнэлэхийн тулд ажилтнуудын мэргэшил, ур чадварыг чухалчлан тогтмол сургалтад хамруулж мэргэжлийн, мэргэшсэн баг бүрдүүлэхэд онцгойлон анхаардаг.



ДААТГАЛЫН ӨРГӨН СҮЛЖЭЭ

Монгол улсын 21 аймаг, Нийслэл хотын дүүрэг бүрт байрласан 33 салбар нэгж, 700 гаруй мэргэшсэн даатгалын төлөөлөгч бүхий даатгалын борлуулалтын хамгийн өргөн сүлжээгээр дамжуулан харилцагчиддаа үйлчилдэг.




НӨХӨН ТӨЛБӨРИЙН БОДИТ БАТАЛГААЖУУЛАЛТ

Эрсдэлийг цаг алдалгүй баталгаажуулахыг зорилго болгож салбартаа хамгийн өргөн бүрэлдэхүүнтэй мэргэшсэн шуурхай албыг 7/24 цагаар Улаанбаатар хотын 4 цэгт байрлуулан ажиллаж байна.


ДААТГАЛЫН САЛБАРЫН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

НИЙТ ХӨРӨНГӨ




■ Нийт хөрөнгө ● Хөрөнгийн өсөлт

НИЙТ ХУРААМЖ




■ Нийт хураамжийн орлого ■ Цэвэр хураамж

НӨХӨН ТӨЛБӨР



■ Нийт нөхөн төлбөр ● Хохирлын харьцаа

ДААТГАЛЫН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ





■ Даатгалын нягтшил % Даатгалын нэвтрэлт

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ



ХУРААМЖИЙН ОРЛОГО

Монгол Даатгал ХК-ийн нийт хураамжийн орлого өмнөх оноос 7.4%-иар өсч 2019 онд 32.7 тэрбум төгрөгт хүрснээр даатгалын салбарт тэргүүлэгч байр сууриа хадгалсан. Цэвэр хураамжийн орлого мөн адил 2019 онд 21.5 тэрбум төгрөгт хүрсэн.



НӨХӨН ТӨЛБӨР

Салбарын нийт компаниудын олгосон нөхөн төлбөрийн дүнгийн 28%-ийг Монгол Даатгал ХК бүрдүүлсэн нь 2019 оны 06-р сард Скай Хайпермаркет ХХК-ийн Имарт Чингис худалдааны төвд гал гарч бараа материалын хохиролд 8 тэрбум төгрөгийг нөхөн төлбөр олгосонтой холбоотой юм.



2019 онд Даатгалын салбарын нийт хөрөнгө 10%-ийн өсөлтийг үзүүлж, нийт хураамжийн орлого мөн 193,6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нөхөн төлбөрийн хувьд 2019 онд 64 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн онтой харьцуулахад 7 тэрбум төгрөгөөр өсч харин хохирлын харьцаа харьцангуй тогтвортой буюу 53% болж буурсан байна.

■ Монгол Даатгал ХК ■ Бусад даатгалын компани

2019 ОНЫ ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

/Аудитлагдсан/


БАЛАНС	2018*	2019
	/мянган төгрөг/	
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	8.3	21,084,718.2
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	13,393.2	22,208,899.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	13,947.5	43,293,617.1
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,108.8	5,296,780.4
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	24,353,846.1
ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ДҮН	10,838.7	13,642,990.6
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	13,947.5	43,293,617.1

ОРЛОГЫН ТАЙЛАН	2018*	2019
	/мянган төгрөг/	
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	-	32,658,573.4
БОРЛУУЛСАН БАРААНЫ ӨРТӨГ	-	22,178,707.8
НИЙТ АШИГ	-	10,479,871.6
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ	(3,075.3)	322,836.5
ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ	(3,075.3)	105,449.3

*2018 оны үр дүн нь "Хорго Хайрхан" ХК-ийн үр дүн бөгөөд 2019 онд "Монгол Даатгал" ХХК-тай нэгдсэн.

САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Нийт хураамжийн орлого




Цэвэр хураамж




Нийт нөхөн төлбөр



Нийт нөөцийн сан



Нийт хөрөнгө



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА 2019



“ДУРААРАА БИШ ЭЭ! ДҮРМЭЭРЭЭ” АЯН

ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтэс, ЗТХЯ, НЗДТГ болон “Монгол Даатгал” ХХК, “Оюу толгой” ХХК, “Мобиком” ХХК нар хамтран хэрэгжүүлсэн зам тээврийн аюулгүй байдлын талаарх олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх “Дураараа биш ээ! Дүрмээрээ” аяны хүрээнд 2019 оны 09-р сарын 23-ны өдрөөс 10 дугаар сарын 23-ны өдөр хүртэлх хугацаанд үйлдэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг өнгөрсөн оны мөн үеэс 16.3, гэмтсэн хүн 22.4, нас барсан хүн 22.2 хувиар тус тус буурсан. Үүнээс нийслэлд үйлдэгдсэн гэмт хэрэг 24.5, орон нутагт үйлдэгдсэн гэмт хэрэг 7 хувиар тус тус буруулсан үр дүнд хүрч чадсан байна.



“МОНГОЛ БАХАРХАЛ”

Үндэсний баяр Цагаан сарыг угтаж нийслэлийн цэцэрлэгүүдийн дунд зохион байгуулсан “МОНГОЛ БАХАРХАЛ” тэмцээнийг “Монголын сургуулийн өмнөх боловсролын багш хөгжлийн төв”-тэй хамтран зохион байгуулж Монгол уламжлал, өв соёл, ёс заншлыг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмэр орууллаа.



“ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ГАРЦ”

Санхүү, эдийн засгийн чиглэлийн их, дээд сургууль, коллежуудын оюутнуудын дунд зохион байгуулсан “Даатгалын зах зээлийн хөгжлийн гарц” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг СЭЗДС-тай хамтран зохион байгуулж, оюутан залуусын боловсролд хөрөнгө орууллаа.



“УЛААНБААТАР МАРАФОН 2019”

Нийслэлийн хэмжээнд зургаа дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа “Улаанбаатар Марафон – 2019” манай компанийн 20 гаруй ажилтан оролцож, нийгэмдээ хамтын оролцоог сануулж, итгэл, найдвар, боломжийг уриаллаа.



“ДААТГАЛ 85” МЭТГЭЛЦЭЭН

Даатгалын салбарын 85 жилийн ойг тохиолдуулан даатгалын салбарын асуудал, шийдлийг мэргэжлийн өнцгөөс хэлэлцэх “Даатгал 85” мэтгэлцээний тэмцээнийг “Монгол Даатгал” ХХК үүсгэн байгуулагдсан 85 жилийн ойн хүрээнд ивээн тэтгэж хамтран ажилласан.



“СУРГУУЛЬ ХҮРЭХ ЗАМ” ХҮҮХДИЙН ГАР ЗУРГИЙН УРАЛДААН

Монгол Даатгал ХХК Цагдаагийн ерөнхий газартай хамтран Улаанбаатар хотын Эрсдэл өндөртэй замаар сургуульдаа явдаг ЕБС-уудын сурагчдын дунд гар зургийн уралдаан зохион байгууллаа. Хүүхдүүд өөрсдийн нүдээр сургуулийн орчныг дүрслэн зурж улмаар албаны хүмүүс болон олон нийтэд мэдээлэн, хүүхдийн аюулгүй орчин, нөхцөлийг сайжруулах зорилготойгоор нийт зорилтод 6 сургуулийн дунд зохион байгуулсан “Сургууль хүрэх зам” гар зургийн уралдаанд нийт 848 сурагч бүтээлээ ирүүлэн оролцлоо.



Сургууль хүрэх зам гар зургийн уралдааны 1-р байранд орсон бүтээл

Замын хөдөлгөөний дүрмийг таниулагч “НОГООН ГЭРЭЛ ЦАГААН ШУГАМ 2019”



Тээврийн цагдаагийн албаны замын цагдаагийн газрын Баянгол дүүрэг дэх замын цагдаагийн хэлтэстэй хамтран Монгол Даатгал ХХК болон Монголын улаан загалмайн нийгэмлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төвтэй хамтран бага насны хүүхдүүдийг зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх болон замын хөдөлгөөнд оролцох зөв дадал хэвшлийг суулгах зорилгоор нийт 22 сургуулийн 242 сурагчдын дунд “Ногоон гэрэл цагаан шугам 2019” тэмцээнийг 2 үе шаттайгаар хамтран зохион байгууллаа.

ХАРИЛЦАГЧДЫН ТӨЛӨӨЛӨЛ

Даатгалын лавлах: 1800-1990
Буухиа даатгал: 7010-1990

Цахим хаяг:

Цахим хуудас: www.mongolmaatgal.mn
Цахим хаяг: insurance@mongolmaatgal.mn
Facebook: [/mongolmaatgal](https://www.facebook.com/mongolmaatgal)
Twitter: [/mongolmaatgal](https://twitter.com/mongolmaatgal)

Төв байр:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо,
Үндсэн хуулийн гудамж 32



CHATBOT QR кодыг
уншуулж нэгдээрэй